



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2004-2005 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2004 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Пүрэв овогтой Оюундэлгэрийг 2004-2005 оны хичээлийн жилээс АНУ-ын Индиана Их сургуулийн магистрантурт олон улсын эрх зүйн чиглэлээр 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

П.ЦАГААН